

Түүх 8: Гидеон ба Гурван зуун цэрэг

Библийн эшлэл
[Шүүгчид 6:12]

ЭЗЭНий тэнгэрэлч түүнд үзэгдэн – Эрэлхэг хүчит дайчин минь,
ЭЗЭН чамтай хамт байна гэсэнд.

Израильчууд Бурханы өмнө гэм нүгэл хийн, хуурамч шүтээн шүтэж, муу зүйл их хийжээ.

Бурхан Израильчуудыг ухааруулахын тулд, Мидиан хүмүүсийг явуулан шийтгэж гэнэ.

Мидианчууд долоон жилийн турш Израильчуудыг зовоожээ.

Израильчууд газар тариалан эрхэлж, ургацаа хураах үед Мидианчууд дайран ирж бүгдийг нь булаан авдаг байв.

Үүгээр ч зогсохгүй үхэр хонь, илжиг гээд бүх хөрөнгийг нь булааж байлаа.

Өөрсдийнх нь гэм буруугаас болж Бурхан уурлаж, тэдэнд шийтгэл өгснийг Израильчууд ойлгожээ.

Тэгээд Бурханд хандан биднийг авраач хэмээн залбирч эхлэв.

Бурхан Израильчуудын залбирлыг сонсоод Гидеоныг сонгожээ.

Гэвч аймхай Гидеон Бурханы үгэнд шууд итгэн дуулгавартай дагаж чадсангүй. Гидеон ингэж хэлэв.

“Хэрэв Бурхан минь надаар дамжуулан Израилийг аврах гэж байгаа юм бол тэмдэг харуулаач! Тариан үтрэмийн шалан дээр ноос тавиад хоноё. Маргааш өглөө зөвхөн ноосон дээр шүүдэр бууж, эргэн тойрны газрыг хуурай байлгаж өгөөрэй.”

Дараагийн өдөр болоход гайхалтай юм болжээ. Шалан дээрх ноос л норсон байсан бөгөөд газар нь хуурай байжээ.

Гэсэн ч Гидеон эргэлзсээр байв. Гидеон дахиад нэг удаа Бурханд ийнхүү хэлэв.

“Бурхан минь, дахиад нэг л удаа тэмдэг үзүүлээч. Энэ удаа эсрэгээрээ ноосыг хуурай байлгаж, эргэн тойронд шүүдэр буулгаж өгөөч.”

Дараагийн өдөр Гидеоны хэлсний дагуу Бурхан үйлджээ.

Гидеон ингэж нэг юм нүдээрээ харж байж Бурхан өөртэй нь хамт байж, өөрт нь үргэлж туслах юм байна гэдэгт итгэж эргэлзэлгүй итгэжээ.

Бурхан Гидеонд Мидианчуудтай тулалдах цэргүүдийг сонго гэж хэлсний дагуу тэрээр маш олон цэрэг цуглуулжээ.

Тэгэхэд Бурхан ингэж хэлэв. “Гидеон! Чамтай хамт тулалдахаар явах цэргүүдийн тоо маш олон байна.

Та нар тулаанд ялвал Миний хүчээр ялсандаа баярлах биш, өөрсдийн хүчээр яллаа гэж бардамнах болно.



Тиймээс чи цэргүүддээ айж байгаа нь гэртээ харь гэж хэл. Тэгээд цэргийнхээ тоог багасга.”

Гидеон цэргүүддээ Бурханы хэлсэн үгийг дамжуулаад айж байгаа нь гэртээ харь гэтэл хорин хоёр мянган цэрэг явж арван мянган цэрэг үлджээ.

Гэтэл Бурхан дахин ингэж айлдав.

“Тэд бас л олон байна. Тэдгээр цэргүүдийг голын эрэг уруу дагуулж яв. Би тэднийг сорих болно.” гэв.

Гидеон цэргүүдийг голын эрэг уруу дагуулж яваад үс уулгав.

Гэтэл Бурхан Гидеонд голын эрэг дээрээс үс уухдаа гараараа үс утган үүж байгаа цэргүүдийг сонго гэж айлдав.

Инээд тэднээс үлдсэн цэрэг нь гурван зуу байлаа.

Тэр шөнө Бурхан Гидеонд ингэж хэлжээ. “Бос, Мидианы хуаран руу оч” гэв.

Гидеон цэргүүддээ нэг гартаа эвэр бүрээ, нөгөө гартаа галт бамбар хийсэн ваар авцгаа гэж хэлэв.

Орой болмогц Гидеон болон бүх цэргүүд хамтдаа эвэр бүрээг үлээн, ваарыг цохиж хагалан бамбараа барин хашхирчээ.

“ЭЗЭНий төлөө, Гидеоны төлөө!”

Энэ чимээг сонссон Мидиан цэргүүд цочин гайхжээ. Тэд айн сандарсандаа бие биенийгээ хөнөөчихөж гэнэ.

Ийнхүү Бурханы тусламжтайгаар Гидеоны удирдсан гурван зуун цэрэг маш олон Мидиан цэргүүдийг ялжээ.



Үйл ажиллагаа 1. Доорх асуултанд хариулаарай.

а. Мидианчууд Израильчуудыг хэр удаан эзэрхийлсэн бэ?

б. Бурхан тэнгэрэлч хэний өмнө гарч ирж, юу гэж айлдсан бэ?

с. Гидеонтой хамт хэдэн цэрэг дайнд гарсан бэ?

● Дараах эшлэлийг уншаад цээжлээрэй. (Шүүгчид 6:12)

ЭЗЭНий тэнгэрэлч түүнд үзэгдэн – Эрэлхэг хүчит дайчин минь, ЭЗЭН чамтай хамт байна гэсэнд.



